



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/55

Чингис хот

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, 16 зүйлийн 16.2, 16.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2017 оны 53 дугаар тогтоолын 5 дугаар бүлгийн 5.8, Эрүүл мэндийн сайдын 2015 оны журам батлах тухай 298 дугаар тушаалын 1дүгээр хавсралт “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 2 дугаар хэсгийн 2.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Галшар суманд үйл ажиллагаа явуулж буй “Эмийн эргэлтийн сан”, Норовлин суманд үйл ажиллагаа явуулж буй Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус 3 жилээр сунгасугай.

2. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



231010164